

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОУАС	Байгаль орчин, уур амьсгалын сан
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
/төгрөгөөр/.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
Менежментийн захидал	17
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН САНГИЙН ЗАХИРАЛ
Л.БААТАРЧУЛУУН ТАНАА

2021.03.25 № 01/383
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-Т заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	471,189,075.00	122,133,201.52
33	АВЛАГА	440,931,348.00	93,830,641.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	147,292.52
33300	Татаас, санхүүжилтийн авлага	436,931,348.00	93,683,349.00
33500	Бусад авлага	4,000,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	4,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	30,257,727.00	28,302,560.00
35400	Хангамжийн материал	30,257,727.00	28,302,560.00
35410	Бичиг хэргийн материал	46,350.00	1,392,433.00
35420	Аж ахуйн материал	28,162,977.00	24,861,727.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,048,400.00	2,048,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,421,374.60	11,583,153.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,421,374.60	11,583,153.79
39200	Биет хөрөнгө	15,701,374.60	11,043,153.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,409,752.91	11,409,752.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,422,925.90)	(5,704,876.50)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,135,000.00	4,354,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,413,166.82)	(4,135,000.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,522,200.00	14,797,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,529,485.59)	(9,678,722.62)
39300	Биет бус хөрөнгө	720,000.00	540,000.00
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(180,000.00)	(360,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	487,610,449.60	133,716,355.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,417,990.00	232,475,040.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,417,990.00	232,475,040.01
41300	Өглөг	54,417,990.00	232,475,040.01
41360	Бусад өглөг	54,417,990.00	232,475,040.01
41361	Байгууллагад төлөх өглөг	54,417,990.00	232,371,702.50
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	103,337.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	433,192,459.60	(98,758,684.70)
51	Засгийн газрын хувь оролцоо	433,192,459.60	(98,758,684.70)
51200	Хуримтлагдсан үр дүн	433,192,459.60	(98,758,684.70)
51210	Өмнөх үеийн үр дүн	836,639,862.26	433,192,459.60
51220	Тайлант үеийн үр дүн	(403,447,402.66)	(531,951,144.30)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	487,610,449.60	133,716,355.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,467,536,669.90	1,421,295,636.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,289,247.96	230,551,901.14
120	Нийтлэг татварын бус орлого	166,289,247.96	230,551,901.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	166,289,247.96	230,551,901.14
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	166,289,247.96	230,551,901.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,301,247,421.94	1,190,743,735.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,881,878,500.00	1,116,812,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,881,878,500.00	1,116,812,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,419,368,921.94	73,931,135.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,419,368,921.94	73,931,135.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,870,984,072.56	1,953,246,780.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,870,984,072.56	1,953,246,780.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,570,733,388.30	1,727,343,051.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,898,849.00	163,274,225.39
210101	Үндсэн цалин	67,708,669.00	64,978,968.00
210102	Нэмэгдэл	81,349,380.00	90,454,457.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,840,800.00	7,840,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,562,979.00	13,442,463.18
210201	Тэтгэврийн даатгал	15,962,579.00	9,562,063.18
210202	Тэтгэмжийн даатгал	900,100.00	970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,100.00	776,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	180,000.00	194,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,200.00	1,940,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,567,869.00	91,118,600.08
210301	Гэрэл, цахилгаан	2,131,750.00	2,558,100.00
210304	Байрны түрээс	87,436,119.00	88,560,500.08
2104	Хангамж, бараа материалын зардал	26,073,552.00	15,378,367.00
210401	Бичиг хэрэг	7,087,224.00	2,168,367.00
210402	Тээвэр, шатахуун	7,099,220.00	5,106,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,887,108.00	7,283,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	820,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,367,900.00	6,208,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,622,200.00	-
210602	Тавилга	6,030,000.00	-
210604	Урсгал засвар	20,715,700.00	6,208,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,214,600.00	-
210702	Дотоод албан томилолт	9,214,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,149,590,345.00	1,139,035,931.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,149,053,777.00	1,134,818,431.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,568.00	396,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	175,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	146,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,457,294.30	298,884,764.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	293,551,744.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,499,799.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,957,495.30	5,333,020.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,250,684.26	225,903,728.98
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	300,250,684.26	225,903,728.98

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	291,978,497.96	225,903,728.98
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,272,186.30	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(403,447,402.66)	(531,951,144.30)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(403,447,402.66)	(531,951,144.30)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,535,463,789.26	1,862,226,984.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,289,247.96	230,551,901.14
120	Нийтлэг татварын бус орлого	166,289,247.96	230,551,901.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	166,289,247.96	230,551,901.14
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	166,289,247.96	230,551,901.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,369,174,541.30	1,631,675,083.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,881,878,500.00	1,116,812,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,881,878,500.00	1,116,812,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,487,296,041.30	514,862,483.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,487,296,041.30	510,862,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	4,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,535,463,789.26	1,861,732,184.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,535,463,789.26	1,861,732,184.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,798,281,757.00	1,542,145,106.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,898,849.00	161,307,728.00
210101	Үндсэн цалин	67,708,669.00	64,978,968.00
210102	Нэмэгдэл	81,349,380.00	88,487,960.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,840,800.00	7,840,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,562,979.00	15,452,915.58
210201	Тэтгэврийн даатгал	15,962,579.00	11,572,515.58
210202	Тэтгэмжийн даатгал	900,100.00	970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,100.00	776,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	180,000.00	194,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,200.00	1,940,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,567,869.00	91,118,600.08
210301	Гэрэл, цахилгаан	2,344,925.00	2,558,100.00
210304	Байрны түрээс	87,222,944.00	88,560,500.08
2104	Хангамж, бараа материалын зардал	25,909,978.00	17,215,950.00
210401	Бичиг хэрэг	6,923,650.00	4,005,950.00
210402	Тээвэр, шатахуун	7,099,220.00	5,106,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,887,108.00	7,283,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	820,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,694,900.00	6,208,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,622,200.00	0
210602	Тавилга	6,030,000.00	0
210604	Урсгал засвар	27,042,700.00	6,208,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,214,600.00	0
210702	Дотоод албан томилолт	9,214,600.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,370,932,783.00	922,689,468.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,370,396,215.00	918,471,968.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,568.00	396,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	175,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	146,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,499,799.00	328,151,744.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	328,151,744.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,499,799.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	737,182,032.26	319,587,077.98
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	737,182,032.26	319,587,077.98

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	291,978,497.96	225,903,728.98
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	445,203,534.30	93,683,349.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	494,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	494,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	494,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	494,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	494,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	(494,800.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ ний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	836,639,862.26	836,639,862.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	836,639,862.26	836,639,862.26
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	(403,447,402.66)	(403,447,402.66)
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	433,192,459.60	433,192,459.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	433,192,459.60	433,192,459.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	(531,951,144.30)	(531,951,144.30)
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	(98,758,684.70)	(98,758,684.70)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,351,936,000.00	1,121,460,772.16	230,475,227.84	83.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,351,936,000.00	1,121,460,772.16	230,475,227.84	83.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,351,936,000.00	1,121,460,772.16	230,475,227.84	83.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,012,400.00	96,328,760.00	683,640.00	99.3
210102	Нэмэгдэл	89,171,600.00	88,487,960.00	683,640.00	99.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,840,800.00	7,840,800.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,026,600.00	7,816,093.58	5,210,506.42	60.0
210201	Тэтгэврийн даатгал	9,146,200.00	3,935,693.58	5,210,506.42	43.0
210202	Тэтгэмжийн даатгал	970,100.00	970,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	776,100.00	776,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	194,000.00	194,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,940,200.00	1,940,200.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,123,500.00	91,118,600.08	4,899.92	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,558,100.00	2,558,100.00	-	100.0
210304	Байрны түрээс	88,565,400.00	88,560,500.08	4,899.92	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,520,300.00	13,047,250.00	473,050.00	96.5
210401	Бичиг хэрэг	4,315,000.00	3,937,250.00	377,750.00	91.2
210402	Тээвэр, шатахуун	5,107,300.00	5,106,400.00	900.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,098,000.00	4,003,600.00	94,400.00	97.7
2107	Томилолт, зочны зардал	2,304,500.00	0	2,304,500.00	-
210702	Дотоод албан томилолт	2,304,500.00	0	2,304,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,134,948,700.00	913,150,068.50	221,798,631.50	80.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,130,706,200.00	908,932,568.50	221,773,631.50	80.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	396,000.00	396,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	175,500.00	22,500.00	88.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	148,500.00	146,000.00	2,500.00	98.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,351,936,000.00	1,121,460,772.16	230,475,227.84	83.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,351,936,000.00	890,908,871.02	461,027,128.98	65.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,351,936,000.00	890,908,871.02	461,027,128.98	65.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	230,551,901.14	(230,551,901.14)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	230,551,901.14	(230,551,901.14)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0		-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		

Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	514,862,483.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,862,483.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,179,134.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,978,968.00
210101	Үндсэн цалин	64,978,968.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,636,822.00
210201	Тэтгэврийн даатгал	7,636,822.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,663,500.00
210401	Бичиг хэрэг	563,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,280,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	820,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,208,700.00
210604	Урсгал засвар	6,208,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,539,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,539,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	328,151,744.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	328,151,744.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,683,349.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	93,683,349.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	93,683,349.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	514,862,483.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	514,862,483.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	510,862,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,000,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Байгаль орчин, уур амьсгалын сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баатарчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэн шалгагдагч этгээдэд өмнөх онуудад үүссэн өр, төлбөрийг барагдуулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хураагдсан эд зүйлийг холбогдох журамд заасны дагуу шийдвэрлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-наас 2020 оны 03 дугаар сарын 19-ны хооронд Ахлах аудитор А.Даваадорж, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, уур амьсгалын сан 2020 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлыг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулахад тус байгууллагын эрхэм зорилго оршино.

Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг судлан тогтоох, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдэд экологийн боловсрол олгох, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон асуудлаар үндэсний болон олон улсын хурал уулзалт зохион байгуулах, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгаль орчин, уур амьсгалын сан санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн, Төсвийн тухай хуулиуд болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,953.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 39.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

33.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 353.9 төгрөгөөр буюу 27.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	440.9	93.8	(347.1)
Бараа материал	30.3	28.3	(2.0)
Үндсэн хөрөнгө	16.4	11.6	(4.8)
Нийт хөрөнгө	487.6	133.7	(353.9)
Өглөг	54.4	232.5	178.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	433.2	(98.8)	(532.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	487.6	133.7	(353.9)

Авлага дансны үлдэгдэл 347.1 сая төгрөгөөр буурсан нь өнгөрсөн оны авлагыг барагдуулсантай холбоотой байна. Авлагын үлдэгдэл 93.8 сая төгрөг нь Сангийн яамнаас авах /нэмэлт санхүүжилтийн/ татаас санхүүжилтийн авлага 93.7 сая, хувь хүмүүсээс авах авлага 0.1 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр буурсан нь 8.0 сая төгрөгийн бараа материалын худалдан авч, 9.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант жилд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 178.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт орж ирээгүйгээс өглөгийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 531.9 төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн алдагдалтай гарсан нь нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд тус санд төвлөрсөн 230.5 сая төгрөгийн орлогын 97.6 сая төгрөг нь нөхөн төлбөр, 35.8 сая төгрөг нь үнэт цаас, 37.1 сая төгрөг нь гэрчилгээний үнэ, 60.0 сая төгрөг нь эрхийн бичиг, тэмдэгтийн хураамж болон бусад орлого байна.

Байгаль орчин, уур амьсгалын сан нь тайлант онд 1,351.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,121.5 сая төгрөг зарцуулж, 230.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нэмэлт санхүүжилтээр 421.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, уур амьсгалын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан байршуулбал зохих 48 мэдээллээс 32 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 16 мэдээлэл нь хамааралгүй гүйлгээ байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 36.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. БОАЖС-ын 2017 оны А/338 "Б дугаар тушаалаар "Байгаль орчны эсрэг гэмт хэргийн улмаас болон захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах, шилжүүлэх шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг БОУАС-д шилжүүлсэн байна. Аудит хийх явцад гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг хадгалсан байдалтай танилцахад 466 нэрийн эд бараа, 1492.2 кг самар, 405.3 кг дэрвэгэр жиргэрүү, 1796 ш цагаан зээрийн эвэр зэрэг нь чанар байдлаа алдсан байдалтай байна. БОАЖС-ын 2019 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан байгалийн баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам"-ын 2.3-д "Зөвлөл нь холбогдох байгууллагаас шилжүүлэн ирүүлсэн байгалийн баялаг, эд зүйлийг хадгалах, үнэлэх, худалдан борлуулах, шилжүүлэх, устгах талаар хэлэлцэн, шийдвэр гаргана" гэсэн заалтын дагуу дээр дурдсан эд барааг журамд заасны дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 36.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өмнөх онд үүссэн өр, төлбөрийн талаар

3.1.1 Илрүүлэлт: Тайлант онд өмнөх онуудад үүссэн 36.2 сая төгрөгийн өр, төлбөрийг барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх, өр төлбөр үүсэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Өмнөх онуудад үүссэн өр, төлбөрийг барагдуулах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Орлогын талаар

3.2.1 Илрүүлэлт: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "БОУАС-ийн хөрөнгө Усны тухай хуулийн 3.1.32-т заасан ус бохирдуулсны төлбөрийн орлого, Агаарын тухай хуулийн 3.1.14-т заасан агаарын бохирдлын төлбөрийн орлогын эх үүсвэрээс бүрдэнэ" гэж заасан боловч Татварын Ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2.10 -д заасны дагуу ус бохирдуулсны төлбөр, мөн хуулийн 7.1, 7.2.8-д заасны дагуу агаарын бохирдлын төлбөр нь Татварын Ерөнхий газарт төвлөрч байна. Иймд уг асуудлыг дээд шатны ТЕЗ-д тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.2.2 Эрсдэл: Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх, орлого тасалдах;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	БОУАС-гийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/12/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, уур амьсгалын сан		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд өмнөх онуудад үүссэн өр, төлбөрийг барагдуулаагүй	36.2	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Л.Баатарчулуун, П.Оюунтунгалаг
2	Сангийн орлогын талаарх эрх зүйн орчныг сайжруулах	-	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Л.Баатарчулуун, П.Оюунтунгалаг
3	Хураагдсан эд зүйлийг холбогдох журамд заасны дагуу шийдвэрлэх	-	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Л.Баатарчулуун, П.Оюунтунгалаг
ДҮН		36.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 414/А0170078

Улаанбаатар хот

СРГ 002/12/СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

БОАЖС-ын 2017 оны А/338 дугаар тушаалаар "Байгаль орчны эсрэг гэмт хэргийн улмаас болон захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах, шилжүүлэх шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг БОУАС-д шилжүүлсэн байна. Аудит хийх явцад гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг хадгалсан байдалтай танилцаж, хяналтын тооллого хийхэд 466 нэрийн эд бараа, 1492.2 кг самар, 405.3 кг дэрэвгэр жиргэрүү, 1796 ш цагаан зээрийн эвэр зэрэг нь чанар байдлаа алдсан байдалтай байна.

Энэ нь БОАЖС-ын 2019 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан байгалийн баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам"-ын 2.3-д "Зөвлөл нь холбогдох байгууллагаас шилжүүлэн ирүүлсэн байгалийн баялаг, эд зүйлийг хадгалах, үнэлэх, худалдан борлуулах, шилжүүлэх, устгах талаар хэлэлцэн, шийдвэр гаргана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хураагдсан эд барааг холбогдох журамд заасны дагуу шийдвэрлэж, тодорхой арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баатарчулуун, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

А.ДАВААДОРЖ

Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

5019126318

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0315auditin 2-R Gazar159.Docx

001080591